

Булган аймаг Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх материал

Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 08 сарын 21-ний өдрийн Дугаар А/419 дүгээр тушаал “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлага”, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан 2023 оны 09 сарын 06-ны өдрийн Дугаар А/470/А-327/А-306 “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог батлах тухай” тушаалын цэгийн тооны хязгаарт багтаан аж ахуйн нэгжид тусгай зөвшөөрөл олгоно.

Үйлчилгээний ажилтан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр “Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай” тушаалд тусгагдсан “Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт”-д хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

Дараах материалыг бүрдүүлнэ.

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг буюу хүсэлт гаргана. Албан бичигт эрхлэх үйлчилгээний төрөл, оноосон нэр, байрлах хаяг, харилцах утас, зөвшөөрлийн ангилал зэргийг тодорхой тусгаж, дараах баримт бичгийг хавсаргана.

2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар (Улсын бүртгэлийн хэлтэс)

3.Тохирлын гэрчилгээ (Стандарт хэмжилзүйн хэлтэс)

4.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас батлагдсан худалдаалах үйл ажиллагаа, хоол үйлдвэрлэлийн газрыг шалгах хяналтын хуудсаар дүгнэхэд бага эрсдэлтэй үнэлэгдэж, улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байх; (Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар

5.Тухайн үйл ажиллагааг эрхлэх байранд хийгдсэн онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын галын дүгнэлт.(Онцгой байдлын газар)

6.Теле, хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага MNS 6423 стандартад нийцсэн камерын системээр тоноглогдсон камер (шөнийн цагаар зураг авдаг бичлэгийг 720 цагаас багагүй буюу 30 хоног хадгалдаг санах ойтой байх)- ын байнгын ажиллагааг хангасан байх; Цагдаагийн байгууллагын тодорхойлолт

7.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдсан гэрчилгээг нэгтгэн <https://e-business.mn/> хаягаар цахимаар ирүүлнэ. (Аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр)

8. Аймгийн Засаг даргын 2023 оны А/631 тоот Захирамжаар томилогдсон Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг баримт бичгийн бүрдлийг магадлан шалгаж, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд хүргүүлж, шийдвэр гаргуулна.

9.Тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гарсаны дараа Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-35.4-д заасан хэмжээгээр татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, цахим төлбөрийн системд зааснаар төвлөрүүлнэ.

Тавигдах шаардлага:

-Хүсэлт гаргагч аж ахуйн нэгж нь ажилтнуудтай Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу гэрээ байгуулан, ажиллах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх бөгөөд ажилтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах,

- Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч дотоод хяналт хэрэгжүүлэгч үлгэрчилсэн журам”-ын дагуу өөрийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байх

- Эзэмшил газрынхаа 30- хувиас доошгүй талбайд ногоон байгууламж, автомашины зогсоол төлөвлөж, бий болгосон байх

- Шөнийн цагаар үйлчилгээ явуулж байгаа барилга байгууламжийн 10 метрээс дээш зайд гадна гэрэлтүүлэг төхөөрөмжийг байршуулах ба гэрэлтүүлэг ойр орчимд байгаа эд зүйл харагдах, камерын бичлэгт орж байхаар гадаад орчны аюулгүй байдлыг хангасан байх.

- СУЭХТАСТТХ-ийн 15.9.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон, татварын байгууллагад хугацаа хэтэрсэн өргүй этгээдэд олгоно.

- Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх зэрэг болно.

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТЭД ХАВСРАХ БАРИМТ БИЧГИЙН БҮРДЭЛ

№	Баримт бичгийн нэр
1	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг (Аж ахуйн нэгж эрхлэх үйлчилгээний төрөл, оноосон нэр, байрлах хаяг, харилцах утас, зөвшөөрлийн ангилал зэргийг тодорхой тусгаж илгээнэ)
2	Улсын байцаагчийн болон ажлын байрны дүгнэлт (Хүнс, хөдөө аж ахуйн газар, Эрүүл мэндийн газар)
3	Галын аюулгүй байдлын дүгнэлт (Онцгой байдлын газар)
4	Хяналтын камерийн тодорхойлолт (Цагдаагийн газар)
5	Татварын өргүй тодорхойлолт (Татварын хэлтэс)
6	Тохирлын гэрчилгээ (Стандарт, хэмжилзүйн хэлтэс)

Эх сурвалж

Овог нэр: Ч.Оюун-Эрдэнэчимэг

Албан тушаал: Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээ , хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн

Утасны дугаар- 99097653

